

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь нэг зүйлтэй бөгөөд тус олон улсын гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах агуулгатай болно.

Тус хэлэлцээр нь олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамуудыг тодорхойлсон бөгөөд хэлэлцээрт оролцогч талуудын уялдуулсан төлөвлөгөө хэлбэрээр 2006 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 62 дугаар чуулганаар батлагдсан.

Соёрхон батлах хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлт нь Транс-Азийн төмөр замын сүлжээнд төмөр замууд хооронд, төмөр замууд болон гаалийн байгууллагууд хооронд харилцан тээврийн цахим мэдээлэл солилцох ерөнхий зарчмуудыг тодорхойлсон.

Энэ нь тус хэлэлцээрийн оролцогч талуудын улс хоорондын төмөр замын тээврийн цахим мэдээлэл солилцох үйл ажиллагааг харилцан уялдуулах зохицуулалт буюу ерөнхий удирдамжийг шинээр бий болгосон.

Улс хоорондын төмөр замын тээврийн цахим мэдээлэл солилцох талаар Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага (ТЗХАБ)-ын хүрээнд гишүүн улсын төмөр замын байгууллагууд хамтран ажиллаж байгаа боловч төмөр зам, гаалийн байгууллагын үйл ажиллагааг хамтад нь уялдуулах олон улсын зохицуулалт одоогоор байхгүй байна.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийж, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулан, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Монгол Улсын Их Хуралд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2006 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Жакарта хотноо хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 62 дугаар чуулганаар баталж, 2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс тус хэлэлцээрийг 2007 оны 10 сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

Тус хэлэлцээр нь олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамуудыг тодорхойлсон бөгөөд оролцогч талууд тус тусын бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих уялдуулсан төлөвлөгөө хэлбэрээр батлагдсан. Хэлэлцээрт 22 улс гарын үсэг зурж, 12 улс соёрхон баталж, 3 улс нэгдэн орж, 2 улс хүлээн зөвшөөрч, 4 улс батлаад байна.

Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2023 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулсан Транс-Азийн төмөр замын сүлжээний ажлын хэсгийн 8 дахь удаагийн хуралдаанаар Исламын Бүгд Найрамдах Иран Улсын санаачилсан дараах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцээрт оруулсан. Үүнд:

1. Хэлэлцээрийн “9 дүгээр зүйл, Хавсралт II-т нэмэлт өөрчлөлт оруулах журам” гэсэнд “9 дүгээр зүйл, Хавсралт II **ба** III-т нэмэлт өөрчлөлт оруулах журам” гэж шинэ гуравдугаар хавсралтын дугаарыг нэмсэн.

2. Хавсралт 3, “Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд” шинэ гуравдугаар хавсралтыг нэмсэн.

Тус зарчмуудын зорилго нь Транс-Азийн төмөр замын сүлжээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцохтой холбоотой оролцогч талуудын зохицуулалтыг уялдуулах, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгоход оршино.

Монгол Улс нь “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн оролцогч улсын хувьд тус хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орсноор төмөр замын тээврийн харилцаа өргөжин хөгжиж, тээврийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй энэ үед төмөр замын тээврийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн практикт нийцүүлэх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм.

Хэлэлцээрийн нэмэлтэд ашигласан нэр томъёог 2006 оны “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”, MNS ISO

2382-1:2000 “Мэдээллийн технологи – Тайлбар толь - Үндсэн нэр томъёо”, MNS ISO 2382-3:1998 “Мэдээлэл боловсруулах систем - Толь бичиг Тоног төхөөрөмжийн технологи” стандартад зааснаар ойлгоно.

Соёрхон батлах хэлэлцээрийн нэмэлт буюу шинэ 3 дугаар хавсралт нь 3 зүйл, 7 хэсэг, 10 заалттай бөгөөд Транс-Азийн төмөр замын сүлжээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцоход баримтлах зарчмуудыг тодорхойлсон бөгөөд энэхүү зарчмууд нь цаашид тус үйл ажиллагааг уялдуулахад олон талт болон бүс нутгийн хэмжээнд хэлэлцээр боловсруулах, тусгай зорилтот ажлын хэсэг байгуулах үндсэн суурь болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана” гэж заасны дагуу “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулсан.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь нэг зүйлтэй байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй.

Хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийлвэрлэсний дагуу Улсын Их Хуралд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж өгнө үү.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**